TEACH *for* MONGOLIA

2024 оны элсэлтийн өргөдлийн гарын авлага

ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Монгол улсын иргэн байх
- Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийн бакалаврын зэрэгтэй байх /2024 оны 6 сарын байдлаар их сургуулиа төгссөн байх/
- Боловсролын тэгш бус байдлыг бууруулахад хувь нэмрээ оруулах чин хүсэлтэй байх.

БИД ХЭНИЙГ ХАЙЖ БАЙГАА ВЭ?

- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэгч
- Боловсролын салбарт хувь нэмрээ оруулах чин хүсэл эрмэлзэлтэй
- Ёс зүй, эерэг хандлагатай шинэ үеийн төлөөлөл
- Өөрийгөө сорих, өөрчлөлтөд дасан зохицох чадвартай

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ

Өргөдлийн шат
3/6-4/15 ны хооронд үргэлжилнэ.
Бүртгүүлэх

II-р шат
4/25-4/30-ний хооронд явагдана.

Эцсийн хариу
5/1-5/10-ны хооронд зарлагдана.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН 1-р ШАТ

Хөтөлбөрийн шалгууртай танилцах

Тавигдах шалгууртай сайтар уншиж танилцаарай.

Хувийн мэдээлэл

- Өөрийн овог нэр, нас, холбоо барих мэдээлэл
- Боловсрол
- Ажлын туршлага гэх мэдээллийг үнэн зөвөөр бөглөөрэй.



Эссээ

Эссээ 2 хэсгээс бүрдэнэ.

ИЛГЭЭХ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН 1-р ШАТ

Тавигдах шалгууртай сайтар уншиж танилцаарай.

Хувийн мэдээлэл



Эссэ

ИЛГЭЭХ

2 -р шат

1-р шатанд тэнцсэн оролцогчид 2-р шатны шалгаруулалтанд оролцоно.

- **ЭССЭ 1.** Та яагаад Тийч фор Монголиа (Teach for Mongolia) хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй байгаа вэ? Хамрагдсанаар та ямар үр дүн, нөлөөллийг бий болгох хүсэлтэй байна вэ? Үгийн тоо 300-500

Зөвлөгөө: Та энэ хэсэгт яагаад уг хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй буйгаа жишээ, баримтаар баяжуулан бичээрэй. Мөн зорьж буй үр дүн, зорилгоо дэлгэрүүлэн бичиж илгээгээрэй.

- **ЭССЭ 2.** Таны хувьд өөрийгөө таньж, хөгжүүлэхэд хамгийн их нөлөөлсөн туршлага, цаг үеийнхээ тухай бичнэ үү. Энэхүү туршлага, цаг үе нь танд хэрхэн, яаж нөлөөлсөн бэ? Үгийн тоо 300-500

Зөвлөгөө: Та энэхүү эссэнд даван туулсан сорилт болон туршлагаа бичээрэй. Мөн тухайн туршлага, мэдлэг таны амьдралд хэрхэн нөлөөлсөн тухай бидэнтэй хуваалцана уу.

2-р шатанд:

- Багшлах дасгал
- Багийн дасгал
- Ганцаарчилсан ярилцлага зэрэг багтана.

Эссээгээ бичихдээ:

- Криллээр,
- Үг үсгийн болон найруулга зүйн алдаагүй бичих хэрэгтэйг анхааараарай.

worki

TEACH for MONGOLIA

БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР

1
- www.worki.mn - нд нэвтэрнэ.
- Эсвэл гар утсаараа Worki аппликейшнийг татаж авна.

Download on the App Store

GET IT ON Google Play

2
- Баруун дээд буланд буй **НЭВТРЭХ** хэсэгт дарж шинэ хэрэглэгчээр бүртгүүлнэ (хэрэв бүртгэлгүй бол)



3
- Хэрэглэгчээр бүртгүүлж хувийн мэдээллээ бөглөнө. Үүний дараа баруун дээд буланд гарч ирэх өөрийн нэр дээр дарж CV-гээ үүсгэнэ.



worki

TEACH for MONGOLIA

4 CV мэдээллээ бөглөх



Та CV хэсэгт харагдах бүх мэдээллээ оруулна.

5 ЭСЭЭ ОРУУЛАХ

- **ЭСЭЭ 1.** Та яагаад Тийч фор Монголиа (Teach for Mongolia) хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй байгаа вэ? Хамрагдсанаар та ямар үр дүн, нөлөөллийг бий болгох хүсэлтэй байна вэ? (Үгийн тоо 300-500)

- **ЭСЭЭ 2.** Таны хувьд өөрийгөө таньж, хөгжүүлэхэд хамгийн их нөлөөлсөн туршлага, цаг үеийнхээ тухай бичнэ үү. Энэхүү туршлага, цаг үе нь танд хэрхэн, яаж нөлөөлсөн бэ? (Үгийн тоо 300-500)

Та зүүн гар талд харагдах **CV ОРУУЛАХ** хэсэгт өөрийн **2 ЭСЭЭГ нэгтгэн 1 файл** болгон оруулна.



worki

TEACH for MONGOLIA

6 АНКЕТ ИЛГЭЭХ

Та өөрийн CV-г үүсгэн, 2 эсээгээ хавсралтаар оруулсны дараагаар дараах байдлаар харагдах хөтөлбөрийн элсэлтэд АНКЕТ ИЛГЭЭХ товчыг дарж анкетаа ирүүлнэ.

"Teach for Mongolia Fellowship" хөтөлбөр 2024 оны элсэлт

30 өдөр

Анкет илгээх

FAQ

Багш бус мэргэжилтнэй хүн уг хөтөлбөрт хамрагдаж болох уу?

Мэдээж боломжтой. Бид багш болон багш бус мэргэжилтэй салбар салбарын манлайлагч залуусыг хайж байгаа бөгөөд мэргэжлийн байгууллагатай хамтран таны бакалаврын зэрэгт үндэслэн дүйцүүлэлт хийж, тохирох хичээлийн чиглэлээр багшийн хөрвөх хөтөлбөрт үнэ төлбөргүй хамруулна.

Хөтөлбөрт хамрагдах гол шалгуур юу вэ?

Хөтөлбөрт хамрагдахын тулд та бакалаврын зэрэгтэй байх шаардлагатай бөгөөд үүнд салбар хамаарахгүй. Хамгийн гол нь та боловсролын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, өөрчлөлтийн нэг хэсэг байж өөрийгөө сорих, нийгэмдээ эерэг өөрчлөлт бий болгох чин хүсэл эрмэлзэлтэй байхад л болно.

Хөтөлбөр яагаад 2 жилийн хугацаатай вэ? Илүү богино хугацаагаар, зайнаас орон нутгийн хүүхдүүдэд багшилж хувь нэмрээ оруулах боломжтой юу?

Харамсалтай нь үгүй. Teach for Mongolia нь Дэлхийн 62 оронд салбартай Teach for All олон улсын холбооны албан ёсны гишүүн бөгөөд бүх салбар орнуудад энэхүү хөтөлбөр нь ижилхэн 2 жилийн хугацаатай зохион байгуулагддаг. Аливаа өөрчлөлт шинэчлэлтийг бий болгоход тодорхой хугацаа, золиос шаардагддаг бөгөөд олон улсын туршлагаар 2 жил нь хөтөлбөрийн залууст тухайн орон нутагт дасан зохицох, асуудлуудыг таньж мэдэн шийдэл бий болгоход тохиромжтой хугацаа юм.

Би ямар хичээл заах вэ?

Таны ерөнхий мэдлэг болон бакалаврын зэрэг эзэмшсэн мэргэжилтэй уялдуулан ямар хичээл заах болон ямар хичээлийн багшаар хөрвөх хөтөлбөрт хамрагдахыг мэргэжлийн байгууллагатай хамтран тодорхойлно. (Жишээ нь: Мэдээлэл технологийн инженер - Мэдээлэл зүйн багш, Эдийн засагч - Математикийн багш, Социологич-Нийгмийн ухааны багш г.м)

Зөвлөмж

- Таны томилогдон очих орон нутгийн дэд бүтцийн байдлаас хамааран амьдрах орон байрны асуудал харилцан адилгүй (сургуулийн дотуур байр, байшин, монгол гэр, ажилчдын байр, орон сууц, г.м) байна.
- Таны томилогдон очих орон нутагт цаг агаарын эрс тэрс уур амьсгалтай, төв суурин газраас алслагдсан байх тул та 2 жилийн хугацаанд эдгээр нөхцлүүдэд эрүүл мэндийн хувьд дасан зохицох чадвартай, ямар нэг эрүүл мэндийн суурь эрсдэл бий эсэхийг бодолцоорой
- Хэрэв та манай хөтөлбөрт шалгаран, томилогдох орон нутаг руу гэр бүлийн гишүүдийн хамт явах бол таны гэр бүлийн гишүүд (эхнэр, нөхөр, эцэг эх, хүүхэд г.м) дээрх нөхцлүүдийг хүлээн зөвшөөрсөн байх нь чухал юм шүү.
- Хэрэв та шалгарсан тохиолдолд хөтөлбөрийн зүгээс зохион байгуулах 4-6 долоо хоногийн (6-7 саруудад) зуны эрчимжүүлсэн сургалтанд хамрагдах шаардлагатай гэдгийг санаарай.

Манай хөтөлбөрийн талаар ЭНД дарж дэлгэрэнгүй танилцаарай.

ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧДЫН ЗӨВЛӨГӨӨ

“Өөрийн чаддаг зүйлсийг бусдын сайн сайхны төлөө зориулаарай. Хүүхэд бүрд биш ч гэсэн чадах чинээгээрээ хүүхдүүдэд урам зориг өгөөрэй. Та чадна.”

Э.Золзаяа Cohort 2022

“Материалаа илгээж буй хүмүүстээ баяр хүргэе. Юуны түрүүнд өөртэйгөө сайн ярилцаж үзээрэй гэж хэлье. яг багш болж чадах эсэх, маш олон өөрчлөлтүүдтэй нүүр тулахдаа бэлэн эсэхээ сайн бодож шийдвэрээ гаргаарай. Амжилт ”

Э.Нямтогтох Cohort 2022

“Хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцохдоо боловсролын талаар мэдээ, мэдээллийн талаар сайн судалбал хэрэгтэй санагдсан. Учир нь түүн дээр тулгууран багийн ажил явагддаг. Мөн багшлах дасгал дээр заах хичээлийн сэдвээ бодоод бэлдээд ирэхэд илүүдэхгүй шүү. “

Д.Болормаа Cohort 2022

“Өөртөө итгэлтэй байгаарай. Таны мэдлэг ур чадвар, таны орон зай хаа нэгтээ дутагдаж байгаа шүү. “

Л.Насанзул Cohort 2022

“Элсэхийг үнэхээр хүсэж байвал ярилцлагын шатандаа түүнийгээ маш сайн харуулаарай. Жишээ нь, яагаад энэ хөтөлбөрийг сонгож байгаа, ямар зорилготой байгаа гэх мэтээр. Бас сандрахгүй, нээлттэй байхыг хичээгээрэй. “

М.Дөлгөөн Cohort 2022

“Өөрийнхөө сул болон давуу талаа сайн мэдэж орж ирээрэй. Энэ нь танд дараа нь асуудлыг шийдвэрлэхэд маш их туслах болноо.”

О.Анхбаяр Cohort 2022

“Хэцүү ч бай баяртай ч бай энэхүү хөтөлбөрт өнгөрөөх цаг хугацаа үнэ цэнтэй байх болно. Сэтгэлийн бэлтгэл мөн аж амьдралын бэлтгэлээ сайн хангаарай. Үргэлж урам өгдөг сайхан номоо цүнхлээрэй. Маш том үйл хэргийн төлөө явж байгаа шүү гэж өдөр бүр өөртөө сануулаарай^^”

Э.Отгончимэг Cohort 2022

“Нөхцөл байдлыг бүх талаас нь авч үзэж, сэтгэл зүйн бэлтгэлтэй байх хэрэгтэй юм шиг санагдсан. Гол нь юу хийж чадахаа, ямар үр дүнд хүрэхээ маш сайн тодорхойлоорой.”

Б.Мөнхзаяа Cohort 2022